

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/08/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)  
Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
Аудитын гол асуудал.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
Орлогын данс.....	11
Зардлын данс.....	11
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ц.МӨНХӨӨ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/238  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд гүйцэтгэл үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагууд улсын төсөвт шилжсэнээр нийт хөрөнгийн хэмжээ 5,693.6 сая төгрөгөөр буюу 69.2 хувиар буурсан байна.

#### Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогоос 5 нэр төрлийн 13.4 сая төгрөгийн орлого тасарсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тосонцэнгэл сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 98.9 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,326,815.0	725,062.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	528,193.0	425,463.9
33	АВЛАГА	266,392.8	178,509.0
35	БАРАА МАТЕРИАЛ	532,229.3	121,089.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,897,445.9	1,805,601.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	10,700.0	110,500.0
37300	Урт хугацаат зээл	10,700.0	110,500.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,886,745.9	1,695,101.5
39200	Биет хөрөнгө	6,710,657.7	1,638,532.2
39300	Биет бус хөрөнгө	176,088.1	56,569.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,224,260.9	2,530,664.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	25,056.5	1,297.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	25,056.5	1,297.4
41300	Өглөг	24,899.7	1,297.4
41400	Урьдчилж орсон орлого	156.8	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,199,204.4	2,529,366.6
51	Засгийн газрын хувь оролцоо	8,199,204.4	2,529,366.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,614,428.9	272,121.3
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,614,428.9	272,121.3
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	249,127.5	249,127.5
51200	Хуримтлагдсан үр дүн	4,084,991.0	1,799,603.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,250,656.9	208,514.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,224,260.9	2,530,664.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,098,406.5	1,312,639.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	260,163.3	368,961.6
110	Орлогын албан татвар	91,541.5	218,558.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	91,541.5	246,831.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-28,272.9
113	Хөрөнгийн албан татвар	102,139.5	100,373.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	66,482.3	50,030.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,044,035.4	-80,047.8
120	Нийтлэг татварын бус орлого	1,044,035.4	-80,047.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,794,207.8	1,023,725.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,500,059.4	1,017,943.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,500,059.4	1,017,943.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,235,578.7	930,071.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,093,098.8	373,057.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	274,893.2	47,939.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	616,787.0	75,216.1
2104	Хангамж, бараа материалын зардал	171,892.3	42,611.2
2105	Нормативт зардал	457,122.1	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,536.0	46,615.2
2107	Томилолт, зочны зардал	3,037.8	1,204.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,610.4	129,627.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	495,601.1	213,800.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,264,480.8	87,872.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	598,347.1	294,695.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	14,289.7	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	90,903.5	5,881,640.0

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	521,733.2	-5,586,944.2
----	---	-----------	--------------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,691,308.7	1,505,724.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	260,163.3	368,961.6
110	Орлогын албан татвар	91,541.5	218,558.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	91,541.5	218,558.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-28,272.9
113	Хөрөнгийн албан татвар	102,139.5	100,373.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	66,482.3	50,030.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,136.6	9,381.0
1181	Газрын төлбөр	2,271.9	4,654.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	46,073.8	35,995.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	735,401.1	113,037.1
120	Нийтлэг татварын бус орлого	735,401.1	113,037.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,695,744.3	1,023,725.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,223,452.9	1,443,239.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,223,452.9	1,443,239.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,959,657.1	1,192,726.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,276,283.3	581,319.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	301,981.2	76,091.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	637,185.7	62,314.2
2104	Хангамж, бараа материалын зардал	297,843.4	286,987.8
2105	Нормативт зардал	260,340.2	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,815.2	48,771.7
2107	Томилолт, зочны зардал	3,037.8	1,204.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,449.3	96,887.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,921.1	39,150.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,263,595.8	250,513.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	467,855.7	62,484.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	157,657.6	35,713.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	157,657.6	35,713.6
2200	Дотоод эх үүсвэрээр	157,657.6	35,713.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-157,657.6	-35,713.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-49,000.0	-129,500.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	39,000.0	119,500.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	10,000.0	10,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	261,198.1	-102,729.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	266,994.9	528,193.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	528,193.0	425,463.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,687,471.2	7,687,471.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	7,366.9	7,366.9

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,694,838.1	7,694,838.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,366.9	-7,366.9
8	Зарласан ногдол ашиг	-10,000.0	-10,000.0
9	Тайлант үеийн үр дүн	521,733.2	521,733.2
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,199,204.4	8,199,204.4
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,199,204.4	8,199,204.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-82,893.6	-82,893.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,116,310.8	8,116,310.8
19	Тайлант үеийн үр дүн	-5,586,944.2	-5,586,944.2
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,529,366.6	2,529,366.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,787,865.0	1,574,387.8	213,477.2	88.1
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,602,474.9	1,454,887.8	147,587.1	90.8
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,259,774.2	1,213,511.9	46,262.3	96.3
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	400,421.5	373,057.9	27,363.6	93.2
210101	Үндсэн цалин	343,468.5	290,754.2	52,714.3	84.7
210102	Нэмэгдэл	40,181.0	53,608.2	(13,427.2)	133.4
210104	Урамшуулал	16,772.0	25,150.6	(8,378.6)	150.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,176.3	47,634.6	2,343.7	95.3
210201	Тэтгэврийн даатгал	34,449.0	32,722.6	1,726.4	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,884.2	3,818.5	65.7	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,184.8	3,018.9	165.9	94.8
210204	Ажилгүйдлийн даатгал	794.1	741.1	53.0	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	7,866.2	7,533.5	332.7	95.8
<b>2103</b>	<b>Баир ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	645,897.8	634,263.0	11,634.8	98.2
210301	Гэрэл, цахилгаан	26,897.0	19,311.5	7,585.5	71.8
210302	Түлш, халаалт	611,850.8	607,801.6	4,049.2	99.3
210303	Цэвэр, бохир ус	7,150.0	7,150.0	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	42,898.6	41,604.8	1,293.9	97.0
210401	Бичиг хэрэг	6,183.3	6,111.1	72.2	98.8
210402	Тээвэр, шатахуун	25,555.3	24,433.5	1,121.9	95.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800.0	4,770.2	29.8	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360.0	290.0	70.0	80.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000.0	6,000.0	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	48,791.7	48,771.7	20.0	100.0
210604	Урсгал засвар	48,791.7	48,771.7	20.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,230.0	1,204.0	26.0	97.9
210702	Дотоод албан томилолт	1,230.0	1,204.0	26.0	97.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,706.3	29,125.9	3,580.4	89.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,232.2	26,655.2	3,577.0	88.2
210803	Даатгалын үйлчилгээ	183.2	183.2	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	205.0	203.6	1.4	99.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77.0	77.0	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,679.6	1,679.6	-	100.0
210807	Газрын төлбөр	329.3	327.3	2.0	99.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,650.0	37,650.0	-	100.0

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0	30,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,650.0	7,650.0	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>342,700.7</b>	<b>241,375.9</b>	<b>101,324.8</b>	<b>70.4</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>312,579.3</b>	<b>211,276.7</b>	<b>101,302.6</b>	<b>67.6</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	312,579.3	211,276.7	101,302.6	67.6
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>30,121.4</b>	<b>30,099.2</b>	<b>22.2</b>	<b>99.9</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,199.2	24,199.2	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,922.2	5,900.0	22.2	99.6
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>185,390.1</b>	<b>119,500.0</b>	<b>65,890.1</b>	<b>64.5</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	185,390.1	119,500.0	65,890.1	64.5
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,787,865.0</b>	<b>1,578,478.0</b>	<b>209,387.0</b>	<b>88.3</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>93,460.1</b>	<b>93,460.1</b>	<b>-</b>	<b>100.0</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	93,460.1	93,460.1	-	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,264,379.1</b>	<b>1,431,273.7</b>	<b>(166,894.6)</b>	<b>113.2</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,264,379.1	1,431,273.7	(166,894.6)	113.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>430,025.8</b>	<b>53,744.3</b>	<b>376,281.5</b>	<b>12.5</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,000.0	47,867.5	11,132.5	81.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000.0	5,876.7	123.3	97.9
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	365,025.8	-	365,025.8	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		166,408.3	166,408.3	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		160,441.6	160,441.6	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,914.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,914.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,914.6</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>377.0</b>
210401	Бичиг хэрэг	42.0
210402	Тээвэр, шатахуун	335.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,037.6</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,037.6
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,500.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,914.6</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,914.6</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,837.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	77.0

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тосонцэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт,

хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оныг Төрийн албан хаагчийн ёс зүйтэй манлайллыг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил болгон зарласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 98.9 хувьтай биелүүлж ажилласан байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 6 байгууллага, 1 аж ахуйн нэгж, 2 сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сум дундын эмнэлэг, соёлын төв гэх нийт 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/33 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн зөвлөмж өгч биелэлтийг хангуулан ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Тосонцэнгэл сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,693.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	528.2	425.5	-102.7
Авлага	266.4	178.5	-87.9
Бараа материал	532.2	121.1	-411.1
Эргэлтийн хөрөнгийн дүн	<b>1,326.8</b>	<b>725.1</b>	-601.7
Урт хугацаат хөрөнгө оруулалт	10.7	110.5	99.8
Үндсэн хөрөнгө	6,886.7	1,695.1	-5,191.6
Нийт хөрөнгө	<b>8,224.3</b>	<b>2,530.7</b>	<b>-5,693.6</b>
Өр төлбөр	25.1	1.3	-23.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,199.2	2,529.4	-5,669.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>8,224.3</b>	<b>2,530.7</b>	<b>-5,693.6</b>

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад урт хугацаат хөрөнгө оруулалт данс өмнөх оноос нэмэгдэж, бусад данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 443.5 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Урт хугацаат зээл 30.1 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 116.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.
2. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,191.6 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

#### Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 1,312.6 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,785.8 сая төгрөг буюу 78.5 хувиар буурсан байна.

#### Хүснэгт №7 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	260.2	369.0	108.8	41.8
Татварын бус орлого	1,044.0	-80.0	-1,124.1	-107.6
Тусламж санхүүжилтийн орлого	4,794.2	1,023.7	-3,770.5	-78.6
Нийт дүн	<b>6,098.41</b>	<b>1,312.64</b>	<b>4,785.77</b>	<b>-78.5</b>

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого зэрэг нь нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 2,192.9 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

#### Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд нийт 6,899.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

#### Хүснэгт №8: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	5500.1	1017.9	4482.1	18.5

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Үйл ажиллагааны бус зардал	90.9	5881.6	-5790.7	6470.2
<b>Нийт дүн</b>	<b>5,590.96</b>	<b>6,899.58</b>	<b>-1,308.62</b>	<b>123.4</b>

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 2,192.9 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын хүрээнд боловсруулж, дээд шатны төсөв захирагч нарт нэгтгэж хүргүүлсэн байна.

Тосонцэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 5/05 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 7/07 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,787.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,475.3 сая төгрөгийг урсгал зардалд, 312.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 93.5 сая төгрөгийг ОНХНС-аас, 1,264.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 365.0 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 59.0 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс, 6.0 сая төгрөгийг зээлийн хүүгийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

#### Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Тус сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 5/05 дугаар тогтоол, 2021 оны 06 дугаар сарын 27-ны 7/07 дугаар төсвийн тодотголын тогтоолд зааснаар Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 340.0 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 398.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 117.2 хувиар давуулан биелүүлсэн байна

#### Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

ҮЗҮҮЛЭЛТ	Жилийн төсөв	Жилийн төсөв /өссөн/	Жилийн гүйцэтгэл /өссөн/	Давалт тасралт	Гүйцэтгэл хувь
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	1,264.4	1,264.4	1,322.7	45.1	104.6
ОРОН НУТГИЙН ОРЛОГО	<b>340.0</b>	<b>340.0</b>	<b>398.4</b>	<b>45.1</b>	<b>117.2</b>
Татварын орлого	314.6	314.6	369.0	41.1	117.3
Орлогын албан татвар	220.9	220.9	246.8	12.7	111.7
Хувь хүний орлогын албан татвар	220.9	220.9	247.0	12.7	111.7
Үйл ажиллагааны орлого	18.0	18.0	31.7	13.7	176.1
Цалин хөлс	165.0	165.0	178.2	13.2	108.0
Хөрөнгийн орлого	35.0	35.0	31.8	-3.2	91.0
Хөрөнгө борлуулсны орлого	2.6	2.6		0.1	103.8
			2.71		
Шууд бус орлого	0.3	0.3	2.34	2.0	780.8
Хувь хүний орлогын албан татвар	-30.7	-30.7	-28.27	2.4	92.1
Хөрөнгийн албан татвар	75.2	75.2	100.4	25.2	133.5
Бууны албан татвар	1.8	1.8	1.95	0.2	108.3
ҮХЭХАТ	3.4	3.4		0.1	102.3
			3.46		
Малд ногдуулах албан татвар	70.0	70.0	94.9	25.0	135.7
Бусад татвар, төлбөр, хураамж	49.2	49.2	50.0	0.8	101.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	12.2	12.2	9.4	-2.8	77.2
Улсын тэмдэгтийн хураамж	6.9	6.9	3.2	-3.7	46.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	0.5	1.1	0.6	227.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.8	4.8	5.1	0.3	105.4
Газрын төлбөр	4.2	4.2	4.7	0.5	110.8
Газрын төлбөр	4.2	4.2	4.6	0.5	110.8
Байгалийн нөөц ашигласны төлбөр	32.9	32.9	36.0	3.1	109.5

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Ойн нөөц ашигласны төлбөр	32.3	32.3	35.4	3.1	109.6
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.6	0.6	0.6	0.0	100.0
Татварын бус орлого	25.4	25.4	29.4	4.0	115.9
Нийтлэг татварын бус орлого	25.4	25.4	29.4	4.0	115.9
Хувьцааны ногдол ашиг	10.0	10.0	10.0	0.0	100.0
Торгуулийн орлого	8.4	8.4	18.7	10.4	223.6
Түрээсийн орлого	5.0	5.0	0.0	-5.0	0.0
Бусад орлого	2.0	2.0	0.7	-1.3	32.9
Тусламжийн орлого	924.4	924.4	924.4	0.0	100.0
Аймаг нийслэлээс сум дүүрэгт авсан санхүүгийн дэмжлэг	924.4	924.3	924.3	0.0	100.0

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Орон нутгийн орлогоос 5 нэр төрлийн 13.4 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн төлөвлөгөө биелээгүй орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 3.2 сая төгрөг, хувь хүний орлогын албан татвар 2.4 сая төгрөг, бусад нийтлэг төлбөр хураамж 2.8 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 3.7 сая төгрөг, бусад орлого 1.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 30.5 сая төгрөгөөр төлөвлөж 30.52 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 100 хувь биелүүлсэн байна.

**Хүснэгт №10: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	9.10	0.1	(8.99)
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	16.00	23.2	7.22
3	Зам ашигласны төлбөр	5.40	7.2	1.79
	<b>Нийт дүн</b>	<b>30.50</b>	<b>30.52</b>	<b>0.02</b>

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ-ын төлөвлөгөө 8.99 сая төгрөгөөр тасарсан байна. Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 7.22 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн, зам ашигласны төлбөр 1.79 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 34.7 сая төгрөгөөр төлөвлөж 48.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 14.0 сая төгрөг буюу 140.3 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

**Хүснэгт №11: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө гүйцэтгэл**

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	10.0	12.7	2.7
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	23.7	32.1	8.4
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	3.9	2.9
4	<b>Нийт дүн</b>	<b>34.7</b>	<b>48.7</b>	<b>14.0</b>

Эх сурвалж: Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 2.7 сая төгрөгөөр, дотоод бараа үйлчилгээний НӨАТ 8.4 сая төгрөгөөр, Агаарын бохирдлын төлбөр 2.9 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

**Тусламж санхүүжилтийн орлогын талаар**

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,787.9 сая төгрөгөөр төлөвлөж, 1,574.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 88.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Төсвийн зарлагын талаар:**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,787.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,475.3 сая төгрөгийг урсгал зардалд, 312.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 65.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр 1,252.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 93.5 сая төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх сангаас 47.9 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлтөөс, 5.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 5,9 сая төгрөг бүрдүүлсэн нь сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүгийн авлага 5.9 сая төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,574.4 сая төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу нийт 213.9 сая төгрөг хэмнэсэн байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 27.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 11.6 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 1.3 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 0.02 сая төгрөг
- Нормативт зардал 11.6 сая төгрөг
- Томилолтын зардал 0.03 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 3.6 сая төгрөг
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 0.02 сая төгрөг
- Эргэж төлөгдөх зээл 65.9 сая төгрөг

Сум хөгжүүлэх сангийн зээлд 185.4 сая төгрөг олгож зээл олголт хийхээр төлөвлөж 119.5 сая төгрөгөөр зээл олголт хийсэн байна.

Орон нутгийн төсөвт 24.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн дүн нь Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 5.9 сая төгрөг, ЕБС-ийн 4.2 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 10.1 сая төгрөг, ИТХ-ын 3.1 сая төгрөг, Соёлын төвийн 0.1 сая төгрөг, ЭМТ-ийн 1.5 сая төгрөгөөс тус тус бүрдэж байна.

Хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээнд 312.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 211.3 сая төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансны үлдэгдэл 101.3 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 5.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 0.1 сая төгрөг, нийт 5.9 сая төгрөгийн санхүүжилт орсон байна.

Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 312.6 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон

аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын биелэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/88 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 20.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 16.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тосонцэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд орон нутгийн орлогын гүйцэтгэлтэй холбоотой 13.5 сая төгрөгийн 1 зөвлөмж, хоршоо хөгжүүлэх

сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 65.1 сая төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Хүснэгт 7 Төлбөрийн акт*, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	445.7	2	367.1	50
Нийт дүн	4	445.7	2	367.1	50

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 182.8 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1 нийт 3 зөвлөмж хүргүүлж байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 6 байгууллага, 1 аж ахуйн нэгж, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 123.6 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн 27.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 95.5 сая төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын төлөвлөгөөнөөс 5 нэр төрлийн 13.4 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

##### 2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

###### 2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлсэн сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл 46.1 сая төгрөг байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан

“Хоршоо хөгжүүлэх сангийн журам”-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

**3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

**3.1. Илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 123.3 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 27.8 сая төгрөгийн 2 албан шаардлага, 95.5 сая төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой	1	46.1					1	46.1				
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	13.4					1	13.4				
Харьяа байгууллагуудын зөрчилтэй холбоотой	1						1					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>59.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>59.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Харьяа байгууллагуудын зөрчил</b>												
Тосонцэнгэл сумын ЗДТГ	3	115.5			1	20.7	2	94.8				
Тосонцэнгэл сумын ИТХ	2	7.5			1	7.1	1	0.4				
Тосонцэнгэл сумын Соёлын төв	1	0.3					1	0.3				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>123.3</b>	<b>3</b>		<b>2</b>	<b>27.8</b>	<b>4</b>	<b>95.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 АХЛАХ АУДИТОР  
 БАТАЛГААЖУУЛСАН:  
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: 10/24.